



МОНГОЛ УЛСЫН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧИЙН АКТ
ЗАВХАН АЙМГИЙН
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР

212800 Улиастай, Завхан аймаг
Утас/факс: 7046-37-02
www.inspection.gov.mn

ЦЭЦЭН-УУЛ СУМЫН БҮРЭН ДУНД
СУРГУУЛИЙН ЗАХИРГААНД

2017.07.06 № 07-07-027/20

Үйл ажиллагааг түр зогсоох тухай.

Цэцэн-уул сумын бүрэн дунд сургуулийн захиргаанаас аймгийн МХГ-г гаргасан хүсэлтийн дагуу тус сургуулийн хичээлийн Б корпусын барилгын төлөв байдал, үүссэн эвдрэл гэмтэл, Барилгын тухай хуулийн хэрэгжилтэд тус сургуулийн захирал С.Ганболд болон холбогдох бусад хүмүүсийг байлцуулан 2017 оны 07-р сарын 03-ний өдөр хяналт шалгалт хийлээ. Уг барилга нь хичээлийн байрын зориулалтаар баригдаж 1979 онд ашиглалтад орсон, энэ үеэс хойш барилгын үндсэн хийцүүдэд их засвар хийгдээгүй, их засвар хийгдээгүйгээс барилгад эвдрэл гэмтэл гарч энэ байдлаар цаашид үргэлжлүүлэн ашиглах боломжгүй байдал үүссэн байна. Барилгын үндсэн хийцүүд: суурь-цутгамал бетон, хана-дүнз, хучилт-мод, дээвэр-төмөр.

Шалгалтаар дараах зөрчлүүд илэрлээ.

Барилгын төмөр дээвэр гадны үйлчлэлд орж зэвэрч цоорон ус тусгаарлах чадваргүй болсоноос анги, өрөөнүүдэд дусаал гоожиж модон дам нуруу, бамбай хучилтад өмхрөлт үүссэн, дээврийн хөндийд сангас, хог шороо ихээр хуримтлагдаж хучилт хотойж цөмрөх, барилгын зүүн талын гадна даацын хана гадагшаа 15-20 см хазайж бүлтрэх аюултай болсон, зүүн талын өрөөний халаалтын системийн өгөх шугам кронштейнээс мултарсан, барилгын гадна хананд 2-3 үед өмхрөлт үүссэн, цаашид барилгад нуралт үүсч осол гарах нөхцөл бүрдсэн, цонх хаалга гажиж хаагдаж нээгдэхгүй, цонхны шил хагарч гялгар цаасаар хаасан, модон шал хөдөлгөөнтэй, барилгын гадна дотор талын шавардлага, шохой хуурч унан өнгө үзэмж алдагдсан зэрэг нөхцөл байдлууд тогтоогдлоо.

Дээрхи байдлууд нь "барилга байгууламжийн материал, хийц, бүтээц, эдлэхүүн нь барилгын ажлын болон ашиглалтын үед иргэдийн эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд аюул учруулахгүй, бат бэх, тогтвортой

2017/07/06

байх” гэсэн Барилгын тухай хуулийн 11-р зүйлийн 11.1.1 заалтын шаардлагыг зөрчиж байна.

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10-р зүйлийн 10.9.7 дахь заалтыг үндэслэн АКТ ТОГТООХ нь:

1.Цэцэн-уул сумын бүрэн дунд сургуулийн хичээлийн Б корпусын барилгад 2017 оны 07-р сарын 05-ний өдрөөс эхлэн илэрсэн зөрчлүүдийг арилгах хүртэл хугацаанд үйл ажиллагаа явуулахыг түр зогсоохоор акт тогтоов.

2.Улсын байцаагчийн акт болон хуулийн хэрэгжилтийг хангуулан ажиллахыг Цэцэн-уул сумын бүрэн дунд сургуулийн захирал С.Ганболдод хариуцуулав.

3.Цэцэн-уул сумын бүрэн дунд сургуулийн захиргаа нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 14-р зүйлд заасаны дагуу улсын байцаагчийн шийдвэрийн талаар шалгалт хийсэн байгууллагын удирдлагад гомдол гаргах эрхтэй.

БАРИЛГЫН ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН

УЛСЫН БАЙЦААГЧИ

Ж.ЦЭДЭН-ИШ

АКТТАЙ ТАНИЛЦАЖ ЗӨВШӨӨРСӨН:

ЗАХИРАЛ

С.ГАНБОЛД